



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
С.ЭНХБОЛД ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022.12.05 № 01/16424

танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газраас жил бүрийн “Авлигын эсрэг олон улсын өдөр 12.09”-ийг угтан улсын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын нийгмийн хор хөнөөлийг ухуулан таниулах, хууль тогтоомжийг сурталчлах зэргээр иргэд, олон нийт, төр, хувийн хэвшлийн оролцоонд түшиглэсэн олон талт хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн.

Энэ жилийн тухайд авлигын эсрэг олон улсын өдрийг НҮБ-ээс зарласан “Дэлхий нийтээрээ авлигын эсрэг нэгдье” уриан дор дэлхийн улс орнууд тэмдэглэж байгаа бөгөөд тус газраас төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах, төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг нэмэгдүүлэх, цахим үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, барилга, зам тээвэр, байгаль орчин, уул уурхай, хүнс, хөдөө аж ахуй зэрэг 8 салбарын холбогдох ажил, үйлчилгээг сонгон хэлэлцүүлж, гаргасан санал зөвлөмжийг шийдвэр гаргах түвшний байгууллага, албан тушаалтанд хүргэх, үр дүнг иргэд, олон нийтэд мэдээлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Авлигатай тэмцэх газар, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас “Эрүүл мэндийн даатгал-Иргэний хяналт-Тусламж үйлчилгээ” сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр хамтран зохион байгуулж, төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрхийг хангах, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт, түүний үр шимийг хүртэх явцад үүсч буй хүндрэл, бэрхшээлийг хэлэлцэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох асуудлаар хэлэлцэж, санал бодлоо нээлттэй солилцсон ба оролцогчдоос гаргасан зөвлөмжийг үүгээр хүргүүлж байна.

Хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл болох 40 хүн танхимаар, 400 хүн цахимаар оролцсон болно.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хамтран ажиллана уу.


Хавсралт 2. хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



З.ДАШДАВАА

142203021416



“ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ-ИРГЭНИЙ ХЯНАЛТ-ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ” ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Зөвлөмж 1. Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн үйл явцыг эрчимжүүлэх, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, гүйцэтгэлийн санхүүжилт, эмийн чанар, аюулгүй байдал, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжтэй холбоотой үйл ажиллагаанд тулгарч буй асуудлуудад тогтмол дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх;

Зөвлөмж 2. Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформыг хөгжүүлэх, нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад ашиглаж байгаа програм хангамж (*үйлчилгээ үзүүлэх, эмчилгээ бүртгэх, цахим жор, цахим лист, цаг олголттой холбоотой e-health, e-hospital, clinic, axis зэрэг*)-ийн өгөгдөл, цар хүрээ, ашиглалтын байдлыг нягтлан судалж, дүн шинжилгээ хийх, үр дүнд тулгуурлан нэгтгэх, нэгдсэн системд холбох, уялдаа холбоог хангахад онцгойлон анхаарах, энэ чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

Зөвлөмж 3. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас даатгалын санхүүжилтээр үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэдээллийг иргэнд хүргэх, чанартай тусламж үйлчилгээ авсан эсэхийг нягтлах зорилгоор үйлчилгээ авсан иргэдийн тодорхой хувьд мессеж илгээх (*SMS үйлчилгээ*) үйлчилгээг нэвтрүүлсэн нь зохих үр дүнд хүрсэн байх бөгөөд цаашид үйлчилгээ авсан даатгуулагч иргэн бүр төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авсан тусламж үйлчилгээний мэдээлэлд цахим байдлаар хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

Зөвлөмж 4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх хүрээнд баримтлах эмнэлзүйн удирдамж (*UPTODATE*)-ийг мөрдүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар ерхийн эрүүл мэндийн төв, сум, тосгоны эрүүл мэндийн төв, хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв, клиник, амаржих газар, нэгдсэн эмнэлэг, сувилал, түргэн тусламжийн төв, сэргээн засав төв, тусгай эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн удирдлага, эмч, ажилтнуудад сургалт, мэдээлэл өгөх ажлыг тогтмол зохион байгуулах;

Зөвлөмж 5. Иргэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хууль тогтоомжоор зөвшөөрсөн болон даатгалын байгууллагатай байгуулсан гэрээнд зааснаас бусад төлбөр, нэмэлт төлбөр авдаг, үйлчлүүлэгч иргэнээр эм, тариа, эмнэлгийн хэрэгслийн төлбөрийг гаргуулдаг, зайлшгүй шаардлагын улмаас уг төлбөрийг гаргуулсан тохиолдолд төлбөрийг буцаан олгодоггүй, төлбөрийг эмчлэгч эмчээс гаргуулахаар шаарддаг, тухайн эмнэлгээс үзүүлэх боломжтой тусламж, үйлчилгээг үзүүлэхгүй бусад эрүүл мэндийг байгууллага руу явуулдаг зэрэг зөрчлийг таслан зогсоох, дахин гаргахгүй байх;

Зөвлөмж 6. Эрүүл мэндийн даатгалын байгууллагад хуурамч, шаардлага хангахгүй нэхэмжлэл илгээдэг, илүү үнэ өртөгтэй тусламж үйлчилгээ үзүүлсэн

мэтээр нэхэмжилдэг, эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн тусламж, үйлчилгээнд зарцуулах зорилгоор эмнэлгүүдэд олгосон санхүүжилтийн тодорхой хэсэг зарцуулагдаагүй (2022 оны 09 дүгээр сарын байдлаар улсын эмнэлгүүд дансандаа 290 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна) зэрэг шалтгааныг тодруулах, хяналт шалгалт хийх, аливаа хууль бус үйлдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Зөвлөмж 7. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад эмч, эмнэлгийн ажилтнуудаас үйлчлүүлэгч иргэнд хүндэтгэлтэй хандах, үйлчилгээ үзүүлэх явцад хүнд суртал, чирэгдэл гаргахгүй байх, үзлэгийн цаг олголт, эмч эмнэлгийн ажилтны зан харилцаа, ёс зүйн байдалд тавих хяналтыг сайжруулахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг авах;

Зөвлөмж 8. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрт тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ иргэн, төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, судлаач, шинжээчдийг татан оролцуулах, хамтран ажиллах;

Зөвлөмж 9. Эмнэлгийн мэргэжилтний хүний нөөцийн бодлогод анхаарал хандуулах, ялангуяа сувилахуйн хүний нөөцийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч хууль зүйн, санхүүгийн, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн үр дүнтэй шийдлийг тодорхойлж, хэрэгжүүлэх талаар санал, санаачилгатай ажиллах;

Зөвлөмж 10. Эрүүл мэндийн сайн дурын нэмэлт даатгалын үйл ажиллагааг эрхэлдэг төрийн бус өмчийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа дэмжих, боломжтой туслалцааг үзүүлэх, хамтран ажиллах.

**“Эрүүл мэндийн даатгал-Иргэний хяналт-Тусламж үйлчилгээ”
хэлэлцүүлгийн оролцогчид**

2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр